

**Монголын Олборлох Үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
Монгол улсын нэгдсэн 5 дугаар тайлан- 2010 он**

Ажлын удирдамж

Үндэслэл

Дэлхийн ОУИТБ-ын Санаачилга нь Засгийн газар, олборлох үйлдвэрлэлийн компаниуд, Иргэний нийгмийн төлөөлөл хамтран олборлох үйлдвэрлэлээс (газрын тос, байгалийн хий болон уул уурхай) төлсөн төлбөр, хүлээн авсан орлогоо ил тод хэвлэн нийтлүүлэх тогтолцоог бий болгон хөгжүүлэхийг дэмжсэн үйл ажиллагаа юм. Мөн олборлох үйлдвэрлэлээс бий болгосон орлогыг ил тод болгох, энэхүү орлогыг үр дүнтэй, нийгэмд үр ашигтай байдлаар зарцуулах бололцоог улам сайжруулах, аливаа улсын олборлох үйлдвэрлэлийн нөөцийг хөгжүүлэх явцад бий болсон хөрөнгийг буруу зорилгоор ашиглах эрсдэлийг багасгахад оршиж байна.

Монгол Улсын Засгийн газраас ОУИТБ-ын Санаачилгад нэгдэх шийдвэрээ 2006 онд анх гаргасан билээ. Үүний дагуу ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, ажлын хэсгийг Засгийн газар, уул уурхайн компани, иргэний нийгмийн төлөөлөгчдийг оролцуулан байгуулж, Санаачилгыг хэрэгжүүлэх үүргийг хүлээлгэсэн байна. ОУИТБ-ын Санаачилгын Монгол Улсын 2006-2009 оны нэгдсэн тайлан гаргах зардлыг олон талт хандивлагчдын Итгэлийн сангаас санхүүжүүлсэн бол Монгол Улсын Засгийн газар 2010 оны аудитын тайлан нэгтгэлийн зардлыг улсын төсвөөс жил бүр гаргахаар шийдэж улсын төсөвт тусгаад байна.

Ажлын хэсэг цомхон ажлын албаны туслалцаатайгаар ОУИТБС-ын ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, уул уурхайн болон газрын тосны үйлдвэрлэл явуулж байгаа болон хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий компаниас бүх шатны (улс, аймаг, дүүрэг, сум) төсөвт төлсөн төлбөр, Засгийн газар тусгай зөвшөөрөл бүхий компаниудаас хүлээн авсан орлогын тайлан гаргах маягтуудыг анх 2007 онд гаргаж, 2008, 2011 оны эхээр шинэчлэн батлуулсан байна.

Монгол Улсын 2006 оны нэгдсэн тайланг Австралийн Крейн Уайт энд Ассоушиэтс хэмээх аудиторын компаниар, 2007 оны тайланг Монгол, Малайзийн Эрнст Янг аудитын компаниудын консорциум, 2008 оны тайланг Их Британийн Харт Нойрс лдт, Монгол Улсын Улаанбаатар аудит корпорацийн консорциум тус тус гаргасан бол 2009 оны нэгдсэн тайланг Их Британийн Харт Нойрс лдт, Монгол Улсын Улаанбаатар аудит корпорацийн консорциум гаргаж байна. Манай улсад энэхүү санаачлагын тайлан гаргах үйл ажиллагаа жилээс жилд өсөн нэмэгдэж, тайлангаар гарах зөрүү тогтмол буурч байна. Тайланд хамрагдсан байдлыг харуулбал:

Он	Тайлан гаргасан компани	Сангийн яамнаас гаргасан тайланд компанийн хамрагдалт	Монгол Улсын нэгдсэн тайланд орсон компани
2006	64	137	25
2007	102	184	38
2008	115	184	46
2009	129	363	101

Тайлбар: 1.2007 онд мөн 2 талдаа тайлан гарсан 28 компанийн тайланг Сангийн яамнаас гаргасан тайлантай нэгтгэх ажиллагааг Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын баг 2008 оны 8 дугаар сард явуулж дүнг Ажлын хэсэгт танилцуулж, сайшаагдсан байна. 2.2009 оны нэгдсэн тайланг 101 компанийн тайланг нэгтгэн Их Британийн Харт Нойрс лдт, Монгол Улсын Улаанбаатар аудит корпорацийн консорциум гаргаж байна.

2010 оны ОУИТБС-ын тайлангаа одоогоор 210 компани гарган Ажлын алба, Ашигт малтмал, Газрын тосны газруудад ирүүлээд байгаа бол Монгол Улсын Сангийн яам уул уурхайн 400 гаруй компаниас хүлээн орлогын тайлан гаргахаар ажиллаж байна.

Монгол Улсын энэхүү санаачлагын хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнд баталгаажуулалт хийсэн дүнг ОУИТБС-ын олон улсын удирдах хороо хэлэлцэн 2010 оны 10 дугаар сард Монгол Улсыг ОУИТБС-ын “стандартыг хангасан 4 дэх орон”-оор зарласан бол 2011 онд ОУИТБС-ын олон улсын Удирдах хорооны нэрэмжит шагналаар манай улс шагнуулсан болно.

Зорилт

ОУИТБС-ын Олон улсын Нарийн бичгийн дарга нарын газраас тогтоосон дэг журмын дагуу энэ ажлыг явуулж, Монголын уул уурхайн болон газрын тосны үйлдвэрлэл, хайгуулын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжээс 2010 онд улсад төлсөн материаллаг төлбөр хийгээд Засгийн газар хүлээн авсан материаллаг орлогын ил тод, үнэн зөв байдлыг баталгаажуулахад оршино. Иймээс уул уурхайн салбарын 2010 оны санхүүгийн жилд төлсөн төлбөр, хүлээн авсан орлогын материаллаг төлбөрийн задлан шинжилгээ, нэгтгэх ажлыг хараат бус, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад, дотоодын аудитын консорциумаар гаргуулахад энэ ажлын зорилт оршиж байна.

Хийх ажлын хүрээ

Энэ ажил нь сонгодог утгаараа санхүүгийн аудит биш юм. Хэдий тийм ч, аудиторын ур чадварыг шаардсан онцгой үүрэгт ажил юм. Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн аудиторын компани, дотоодын аудитын компанитай хамтран консорциум байгуулан энэ удирдамж бүхий ажлыг хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Сонгон шалгаруулалтад тэнцсэн аудиторын консорциум нь дараахь ажлыг гүйцэтгэнэ.

1.2010 оны санхүүгийн жилд Засгийн газарт уул уурхай, газрын тосны үйлдвэрлэл, хайгуулын тусгай зөвшөөрөл, бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий сонгогдсон компаниадаас төлсөн бүх материаллаг төлбөр, уул уурхайн компаниудаас хүлээн авсан материаллаг орлогуудад задлан шинжилгээ хийнэ.

а/Задлан шинжилгээ хийгдэх анхан шатны баримт бичиг нь батлагдсан маягтын дагуу компани бүрийн бөглөн гаргасан тайлан, компани бүрээр гарсан Засгийн газрын тайлан байна.¹ Шаардлагатай гэж үзвэл, аудиторын консорциум нь гарсан зөрүүтэй холбогдох төлсөн ба хүлээн авсан үндсэн санхүүгийн баримтууд, тэдгээрийн санг үзэх, шалгах эрхээр хангагдана.

б/Санхүүгийн өгөгдөл мэдээллийг энэхүү ОУИТБС-ын тайланд оруулах боломжийг хангах үүднээс компанийн 2010 оны санхүүгийн жилийн тайлагнах материаллаг төлбөрийн хэмжээг хамгийн багадаа 50,000,000 төгрөгөөр тооцно (150 хүртэл компанийх гэсэн үг).

в/Холбогдох бүх талуудын талаар мэдээлэлтэй болох учир тэдний талаар мэдээллийг нууцлах өндөр хариуцлагыг аудиторын консорциум хүлээнэ.

2.Компаниас төлсөн төлбөр, Засгийн газрын хүлээж авсан орлогыг нэгтгэсэн тайланг англи, монгол дээр, нэгдсэн, компани, төлбөр, төрийн байгууллага бүрээр тус тус гаргана:

а/Аудиторын консорциум нь төлбөр, орлогын хооронд ямар нэг зөрүү гарвал 2 талаас тайлбар гаргуулах ба аудиторын консорциум мэргэжлийн дүгнэлт гаргаж, бүх зөрүү тайлбартай байхыг хангах үүрэгтэй;

б/Бүх зөрүүний судалгаа, холбогдох компани, Засгийн байгууллага, зөрүүтэй дүн бүрээр нь болзошгүй шалтгааны хамт тусад нь гаргана;

в/Төлбөр, орлогын материаллаг байдлыг 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн Үндэсний зөвлөлийн хурлаар батлагдсан тодорхойлолтын дагуу тогтооно;

¹ Тайлангийн маягтад орсон компанийн тоон үзүүлэлт нь аудитороор хянуулж, баталгаажуулсан компанийн санхүүгийн жилийн тайлан байна.

г/Бүх хандив тусламжийн судалгааг холбогдох компани, Засгийн газрын байгууллага бүрээр Сангийн сайдын 2010 оны 45 дугаар тушаалын биелэлтийн хамт гаргана;
д/Тайлангийн нэгтгэлд оролцож буй компаниудаас тэдгээр компаниудын 2010 оны санхүүгийн нэгдсэн тайлан ямар аудиторроор баталгаажсан, олон улсын санхүүгийн тайлагналын стандарт мөрдөгдсөн эсэх судалгааг компани бүрээр гаргана;
е/Тайлангийн нэгтгэлд орж буй компаниудын ашиглалт, хайгуулын зөвшөөрөл, байгаль орчны нөхөн сэргээлтийн тайлан болон тайлангийн жилийн уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийн судалгааг гаргана;
ж/Бүх компани, Засгийн газрын байгууллагуудын ажил хариуцсан болон харилцсан албан тушаалтнуудын талаар лавлагаа гаргана;
з/Тайланд оролцсон байгууллагууд ил тод байдал, харилцааны соёлын талаар ямар байсныг тайландаа дүгнэлт оруулж, нээлттэй байдлын судалгааг тусад нь гаргана;
и/Тайланд өгөгдөл мэдээний чанар болон нийт явцын талаархи аудиторын консорциум санал дүгнэлт орсон байна;
л/Аудиторын консорциум нь цаашдаа ажлыг сайжруулах талаар Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд хийж болох зүйлийн талаархи зөвлөмж, зөрүүний шалтгааныг илрүүлэх зорилгоор нарийвчилсан зөвлөмжийг тайландаа оруулж өгнө.

Аудиторын консорциумын тайланг англи, монгол дээр гарган эхлээд Монголын ОУИТБС-ын ажлын хэсгийн хэлэлцүүлэгт оруулж, зөвшөөрлийг авна. Хэвлүүлж, нийтэд түгээхээс өмнө тайланг Үндэсний зөвлөлд оруулж, батлуулах шаардлагатай.

Ажлын хэсэг дээр хэлэлцүүлж, Үндэсний зөвлөлөөр батлуулан зөвшөөрүүлсний дараа, тайлан болон хүрсэн үр дүнг хэвлүүлэх, нийтэд түгээх ажлыг Ажлын хэсгийн удирдлагын дор хэрэгжүүлнэ.

Аудитын стандарт

Мөнгөн болон хандивын төлбөрүүдийг тооцоонд авч, нэгтгэлийг мөнгөн суурьтай нягтлан бодох бүртгэлийн аргаар явуулна.

Аудиторын ур чадвар

Аудитор нь гадаад, дотоодын аудитын компаниудын консорциум байх ба дараахь шаардлагыг хангасан байна:

а/ нягтлан бодохын мэргэжлээрээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн удирдагчтай (олон нийтийн эрх бүхий нягтлан бодогч, мэргэшсэн нягтлан бодогч, эсхүл мэргэшсэн нягтлан бодогчтой адил түвшиний ур чадвартай) болох нь нотлогдсон,

б/ Олон улсын Нягтлан бодогчдын холбоонд харьяалагдах нягтлан бодохын байгууллагын мэргэшсэн гишүүн нягтлан бодогчтой байна. Компани нь шаардлага хангасан ажилтнуудтай байх хийгээд үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх чадавхитай байна.

в/ ОУИТБ-ын санаачилгын талаар зохих мэдлэгтэй, энэ чиглэлээр өмнө нь тайлангийн нэгтгэл хийж байсан туршлагатай.

г/ Консорциумд оролцох дотоодын аудитын компани нь аудит хийх тусгай зөвшөөрлийг Монгол Улсын Сангийн яамнаас авсан, тэр нь хүчинтэй байх ёстой. Оролцох сонирхолоо илэрхийлэхдээ тусгай зөвшөөрлийн хуулбарыг хавсралтаар ирүүлнэ.

Сонгон шалгаруулалт, гэрээ байгуулах

Аудиторын консорциумыг Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчин хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 39 дүгээр заалтын дагуу Зөвлөх сонгох хосолмол үнэлгээний аргын дагуу сонгон шалгаруулна. Гэрээ байгуулах эрх бүхий байгууллага нь Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын Санаачилгын ажлын алба байна.

Хугацаа

Аудиторын консорциум нь Засгийн газар, уул уурхайн компаниудаас гарган ирүүлсэн тайлангийн маягтуудыг Монголын ОУИТБС-ын ажлын албанаас хүлээн авснаас хойш 60 хоногт багтаан тайлангуудаа орчуулгын хамт гаргасан байна.

Энэхүү тендерт оролцох сонирхолоо дээр дурдсан чадвар, шаардлагын дагуу баримт бичигүүдээ бүрдүүлэн 2011 оны 5 дүгээр сарын 20-ны 17⁰⁰ цагаас өмнө Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын ажлын албанд ирүүлнэ үү.

Хаяг: Монголын Олборлох үйлдвэрлэлийн Ил тод байдлын санаачлагын ажлын алба

Туушин компанийн төв байр, 512 тоот
Ерөнхий сайд А. Амарын гудамж,
Улаанбаатар хот, 210620А
Монгол улс

Утас 976- 70 11 05 25

Факс 976- 70 11 01 55

И- мейл: eiti.secretariat.mn@gmail.com

Вебсайт: www.eitimongolia.mn